ХОВД АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

# САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Мянгад сумын төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2023 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын хураангуй тайлан

**Аудитын код:** ХОА-2024/11/НА-СТА-ТТЗ


| | |
|---|---|
| Цахим хуудас: www.audit.mn<br>Ховд хот<br>2024 он | Дарга, тэргүүлэх аудитор: Х.Болдбаатар<br>Утас: 99047408 Цахим хаяг: boldbaatarkh@audit.gov.mn<br>Аудитын менежер: А.Цэцэгсүрэн<br>Утас: 99013699 Цахим хаяг:tsetsegsurena@audit.gov.mn<br>Аудитор: М.Энхжаргал<br>Утас:99812792 Цахим хаяг: Enkhjargalm@audit.gov.mn |


Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

ХОВД АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
84000 Цамбагарав баг, Жаргалант сум, Ховд
Утас: 976-70433061, Факс: 976-70433061
E-mail: khovd@audit.gov.mn

2024-06-25 № 1/124
танай 2024-06-05 -ны № 01/81 -т

МЯНГАД СУМЫН ТӨСВИЙН
ТӨВЛӨРҮҮЛЭН ЗАХИРАГЧ
М.БААТАР ТАНАА

**Өөрчлөлтгүй дүгнэлт**

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.2-д заасны дагуу Мянгад сумын төсвийн төвлөрүүлэн захирагчийн нэгтгэсэн 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Мянгад сумын төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

**Дүгнэлтийн үндэслэл**

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

**Асуудлыг онцолсон хэсэг**

Санхүүгийн нэгтгэсэн тайланд харьяа 2 төсөвт байгууллага, 2 тусгай сан, сумын ерөнхий боловсролын сургууль, цэцэрлэг, соёлын төв, зэрэг байгууллагуудын тогтмол зардлыг сумын төсвийн төвлөрүүлэн захирагчийн тайланд нэгтгэгдсэн байна.

Мянгад сумын орон нутгийн орлогын төлөвлөгөө 80.7 сая төгрөгөөр буюу 21 хувиар давж биелсэн байна.

**Аудитын гол асуудал**

Тайлант онд улсын төсвийн болон орон нутгийн хөрөнгө оруулалтаар биет хөрөнгө 235.8 сая төгрөгөөр нэмэгдсэн байна.

**Бусад асуудлын хэсэг**

Байгууллагын удирдлага бусад мэдээлэлтэй холбоотой үүрэг хариуцлагыг хүлээнэ.

Сумын Засаг даргын 2023 оны жилийн эцсийн үнэлгээ, сумын засаг дарга, аймгийн Засаг даргатай байгуулсан гэрээний хэрэгжилт ажлын үр дүнг аймгийн засаг даргын 2023.12.27-ны өдрийн А/886 дугээр захирамжаар 90.2 хувийн гүйцэтгэлтэй гэж тайлагнасан байна.

Мянгад сумын Засаг даргын санхүүгийн нэгтгэсэн тайлангаас бусад үйл ажиллагааны тайлан, мэдээ, гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлт зэрэг мэдээлэлтэй танилцахад материаллаг буруу илэрхийлсэн зүйл илрээгүй.

**Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага**

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

**Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР Х.БОЛДБААТАР

## 2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

### 2.1 Аудит хийсэн нэгтгэсэн санхүүгийн байдлын тайлан (мянган төгрөгөөр)

| Код: | Тайлангийн үзүүлэлт | 2022 оны 12-р сарын 31 | 2023 оны 12-р сарын 31 |
|---|---|---|---|
| **1** | **ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН** | 570,652.74 | 718,843.60 |
| **31** | **МӨНГӨН ХӨРӨНГӨ** | 190,215.00 | 386,494.80 |
| **33** | **АВЛАГА** | 210,651.30 | 225,587.80 |
| **34** | **УРЬДЧИЛГАА** | 116,723.70 | 34,395.00 |
| **35** | **БАРАА МАТЕРИАЛ** | 53,062.80 | 72,366.00 |
| **2** | **ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН** | 1,440,698.30 | 1,600,975.40 |
| **39** | **ҮНДСЭН ХӨРӨНГӨ** | 1,440,698.30 | 1,600,975.40 |
| **39200** | **Биет хөрөнгө** | 1,399,320.80 | 1,560,085.40 |
| **39300** | **Биет бус хөрөнгө** | 41,377.50 | 40,890.00 |
| **3** | **НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II** | 2,011,351.00 | 2,319,818.90 |
| **4** | **НИЙТ ӨР ТӨЛБӨР** | 18,560.40 | 820.2 |
| **41** | **БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР** | 18,560.40 | 820.2 |
| **41300** | **Өглөг** | 18,560.40 | 820.2 |
| **5** | **ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН** | 1,992,790.60 | 2,318,998.80 |
| **51** | **Засгийн газрын хувь оролцоо** | 1,992,790.60 | 2,318,998.80 |
| 51100 | Засгийн газрын оруулсан капитал | 561,660.10 | 561,660.10 |
| **51200** | **Хуримтлагдсан үр дүн** | 1,045,419.40 | 1,371,627.50 |
| 51300 | Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү | 385,711.20 | 385,711.20 |
| **6** | **ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V** | 2,011,351.00 | 2,319,818.90 |

### 2.2 Аудит хийсэн нэгтгэсэн санхүүгийн үр дүнгийн тайлан (мянган төгрөгөөр)

| Код: | Тайлангийн үзүүлэлт | 2022 оны 12-р сарын 31 | 2023 оны 12-р сарын 31 |
|---|---|---|---|
| **I** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)** | 2,793,682.10 | 2,149,374.10 |
| **11** | **ТАТВАРЫН ОРЛОГО** | 316,590.60 | 405,140.70 |
| **110** | **Орлогын албан татвар** | 224,967.90 | 288,987.50 |
| **1100** | **Хувь хүний орлогын албан татвар** | 224,967.90 | 305,615.80 |
| **1101** | **Хувь хүний орлогын албан татварын буцаан олголт** | | -16,628.20 |
| **113** | **Хөрөнгийн албан татвар** | 59,283.10 | 65,106.10 |
| **118** | **Бусад татвар, төлбөр, хураамж** | 32,339.60 | 51,047.00 |
| **12** | **ТАТВАРЫН БУС ОРЛОГО** | 190,517.70 | 289,677.20 |
| **120** | **Нийтлэг татварын бус орлого** | 190,517.70 | 289,677.20 |
| **13** | **ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО** | 2,286,573.80 | 1,454,556.20 |
| **II** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН** | 2,699,735.30 | 1,823,166.00 |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | 2,699,735.30 | 1,823,166.00 |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | 1,583,775.60 | 1,821,254.00 |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | 393,232.60 | 485,487.00 |

| | | | |
|---|---|---|---|
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | 48,232.90 | 60,792.70 |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | 401,000.60 | 43,907.10 |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | 339,775.00 | 414,943.10 |
| **2105** | **Нормативт зардал** | 335.3 | 446 |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | 2,521.40 | 2,829.20 |
| **2107** | **Томилолт, зочны зардал** | 2,720.70 | 5,937.10 |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | 11,304.80 | 425,553.90 |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | 384,652.30 | 381,357.90 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | 1,115,959.80 | 1,912.00 |
| **III** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III)=(I)-(II)** | 93,946.80 | 326,208.10 |
| **V** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН** | 5,160,307.10 | |
| **VI** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI)=(III)+(IV)-(V)** | -5,066,360.30 | 326,208.10 |

**2.3 Аудит хийсэн нэгтгэсэн мөнгөн гүйлгээний тайлан** **(мянган төгрөгөөр)**

| **Код:** | **Тайлангийн үзүүлэлт** | **2022оны 12-р сарын 31** | **2023 оны 12-р сарын 31** |
|---|---|---|---|
| **I** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I)** | 2,690,961.40 | 1,911,258.20 |
| **11** | **ТАТВАРЫН ОРЛОГО** | 316,590.60 | 405,140.70 |
| **110** | **Орлогын албан татвар** | 224,967.90 | 288,987.50 |
| **1100** | **Хувь хүний орлогын албан татвар** | 224,967.90 | 305,615.80 |
| **1101** | **Хувь хүний орлогын албан татварын буцаан олголт** | | -16,628.20 |
| **113** | **Хөрөнгийн албан татвар** | 59,283.10 | 65,106.10 |
| **118** | **Бусад татвар, төлбөр, хураамж** | 32,339.60 | 51,047.00 |
| **1180** | **Бусад нийтлэг төлбөр, хураамж** | 16,498.10 | 25,077.60 |
| **1181** | **Газрын төлбөр** | 10,981.60 | 13,061.30 |
| **1182** | **Байгалийн нөөц ашигласны төлбөр** | 4,859.90 | 12,908.20 |
| **120** | **Нийтлэг татварын бус орлого** | 80,568.20 | 51,561.30 |
| **13** | **ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО** | 2,293,802.60 | 1,454,556.20 |
| **II** | **НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН** | 2,210,679.70 | 1,289,825.20 |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | 1,072,481.10 | 1,287,913.20 |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | 388,622.30 | 482,284.40 |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | 48,660.80 | 60,285.60 |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | 404,305.70 | 42,799.00 |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | 16,472.90 | 19,394.20 |
| **2105** | **Нормативт зардал** | 335.3 | 502.5 |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | 4,033.90 | 2,737.30 |

| | | | |
|---|---|---|---|
| **2107** | **Томилолт, зочны зардал** | 2,720.70 | 5,937.10 |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | 32,343.10 | 437,541.00 |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | 174,986.40 | 236,432.20 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | 1,138,198.60 | 1,912.00 |
| **III** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II)** | 480,281.70 | 621,433.00 |
| **V** | **ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (V)** | 368,345.10 | 371,053.20 |
| **22** | **ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ** | 368,345.10 | 371,053.20 |
| **2200** | **Дотоод эх үүсвэрээр** | 368,345.10 | 371,053.20 |
| **VI** | **ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VI)=(IV)-(V)** | -368,345.10 | -371,053.20 |
| **VII** | **САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ДҮН** | -138 | -54,100.00 |
| **23** | **ЭРГЭЖ ТӨЛӨГДӨХ ТӨЛБӨРИЙГ ХАССАН ЦЭВЭР ЗЭЭЛ** | 138 | 54,100.00 |
| **VIII** | **НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VIII)=(III)+(VI)+(VII)** | 111,798.60 | 196,279.80 |
| 101 | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл | 78,416.40 | 190,215.00 |
| 20 | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл | 190,215.00 | 386,494.80 |

**2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан** **(мянган төгрөгөөр)**

| **Код** | **Үзүүлэлт** | **Засгийн газрын оруулсан капитал** | **Дахин үнэлгээний нөөц** | **Хуримтлагдсан дүн** | **Засгийн газрын хувь оролцооны нийт дүн** |
|---|---|---|---|---|---|
| **1** | **2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл** | **2,472,279.4** | **2,138,621.7** | **2,443,670.0** | **7,054,571.0** |
| **2** | **Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт** | **-1,910,619.4** | **-1,752,910.4** | **3,668,109.7** | **4,579.9** |
| **3** | **Дахин илэрхийлсэн үлдэгдэл** | **561,660.1** | **385,711.2** | **6,111,779.6** | **7,059,150.9** |
| **4** | **Тайлант үеийн үр дүн** | | | **-5,066,360.3** | **-5,066,360.3** |
| **5** | **2022 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл** | **561,660.1** | **385,711.2** | **1,045,419.4** | **1,992,790.6** |
| **6** | **2023 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл** | **561,660.1** | **385,711.2** | **1,045,419.4** | **1,992,790.6** |
| **7** | **Дахин илэрхийлсэн үлдэгдэл** | **561,660.1** | **385,711.2** | **1,045,419.4** | **1,992,790.6** |
| 8 | Тайлант үеийн үр дүн | | | 326,208.1 | 326,208.1 |
| **9** | **2023 оны 6-р сарын 30-наарх үлдэгдэл** | **561,660.1** | **385,711.2** | **1,371,627.5** | **2,318,998.8** |

**2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан** **(мянган төгрөгөөр)**

| **Код** | **Үзүүлэлт** | **Төлөвлөгөө** | **Төсвийн гүйцэтгэлийн тайлан** |
|---|---|---|---|
| **II** | **НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН** | **1,603,206.90** | **1,444,782.97** |

| | | | |
|---|---|---|---|
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **1,096,186.50** | **1,088,975.88** |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | **1,094,274.50** | **1,087,063.88** |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | **482,284.40** | **482,284.40** |
| 210101 | Үндсэн цалин | 278,261.70 | 276,993.32 |
| 210102 | Нэмэгдэл | 140,525.20 | 127,913.12 |
| 210103 | Унаа хоолны хөнгөлөлт | 0 | 4,269.00 |
| 210104 | Урамшуулал | 11,703.00 | 47,242.76 |
| 210105 | Гэрээт ажлын хөлс | 51,794.50 | 25,866.20 |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | **60,285.60** | **60,285.60** |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 40,994.10 | 40,994.10 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 4,822.80 | 4,822.80 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 3,858.30 | 3,858.30 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 964.60 | 964.60 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 9,645.80 | 9,645.80 |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | **444,473.50** | **438,276.45** |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 26,341.90 | 26,176.83 |
| 210302 | Түлш, халаалт | 378,577.40 | 373,129.57 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 39,554.20 | 38,970.05 |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | **19,904.10** | **19,394.19** |
| 210401 | Бичиг хэрэг | 2,497.40 | 2,496.30 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 13,971.60 | 13,970.99 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 3,435.10 | 2,926.90 |
| **2105** | **Нормативт зардал** | **502.50** | **502.50** |
| 210503 | Нормын хувцас, зөөлөн эдлэл | 502.50 | 502.50 |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | **8,435.40** | **8,411.90** |
| 210603 | Хөдөлмөр хамгааллын хэрэглэл | 280.60 | 280.60 |
| 210604 | Урсгал засвар | 8,154.80 | 8,131.30 |
| **2107** | **Томилолт, зочны зардал** | **5,963.60** | **5,937.10** |
| 210702 | Дотоод албан томилолт | 5,963.60 | 5,937.10 |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | **36,842.60** | **36,388.93** |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 35,077.70 | 35,077.70 |
| 210802 | Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох | 369.40 | 100.00 |
| 210803 | Даатгалын үйлчилгээ | 145.00 | 145.00 |
| 210804 | Тээврийн хэрэгслийн татвар | 225.00 | 77.86 |
| 210805 | Тээврийн хэрэгслийн оношлогоо | 30.00 | 0 |
| 210806 | Мэдээлэл, технологийн үйлчилгээ | 872.50 | 872.50 |
| 210807 | Газрын төлбөр | 123.00 | 115.87 |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | **35,582.80** | **35,582.80** |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 34,182.40 | 34,182.40 |

| | | | |
|---|---|---|---|
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 1,400.40 | 1,400.40 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | **1,912.00** | **1,912.00** |
| **2132** | **Бусад урсгал шилжүүлэг** | **1,912.00** | **1,912.00** |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 1,912.00 | 1,912.00 |
| **22** | **ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ** | **437,020.40** | **301,707.10** |
| 220001 | Барилга байгууламж | 293,628.90 | 158,966.57 |
| 221001 | Их засвар | 72,234.80 | 77,583.83 |
| 222001 | Тоног төхөөрөмж | 22,672.00 | 22,672.00 |
| 223001 | Бусад хөрөнгө | 48,484.70 | 42,484.70 |
| **23** | **ЭРГЭЖ ТӨЛӨГДӨХ ТӨЛБӨРИЙГ ХАССАН ЦЭВЭР ЗЭЭЛ** | **70,000.00** | **54,100.00** |
| 230001 | Эргэж төлөгдөх зээл | 70,000.00 | 54,100.00 |
| **III** | **ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР** | **1,603,206.90** | **1,544,287.38** |
| **32** | **ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ** | **1,465,766.20** | **1,515,794.58** |
| 320001 | Орон нутгийн төсвөөс | 1,142,226.50 | 1,192,254.88 |
| 320002 | Орон нутгийн хөгжлийн сангаас санхүүжих | 323,539.70 | 323,539.70 |
| **35** | **ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС** | **137,440.70** | **28,492.80** |
| 350001 | Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 605.00 | 652.00 |
| 350002 | Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 52,731.90 | 27,840.80 |
| 350003 | Урьд оны үлдэгдлээс санхүүжих | 84,103.80 | 0 |
| 4 | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл | 0 | 107,390.75 |
| 5 | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл | 0 | 206,895.15 |
| **6** | **ТӨСВИЙН БУСАД МЭДЭЭЛЛИЙН АНГИЛАЛ** | **62** | **62** |
| **61** | **БАЙГУУЛЛАГЫН ТОО** | **2** | **2** |
| 610001 | Төсвийн байгууллага | 2 | 2 |
| 610002 | Төсвөөс гадуур байгууллага | 0 | 0 |
| **62** | **АЖИЛЛАГСАДЫН ТОО** | **30** | **30** |
| 620001 | Удирдах ажилтан | 9 | 9 |
| 620002 | Гүйцэтгэх ажилтан | 9 | 9 |
| 620003 | Үйлчлэх ажилтан | 5 | 5 |
| 620004 | Гэрээт ажилтан | 7 | 7 |
| **65** | **ОРОН ТООНЫ МЭДЭЭЛЭЛ** | **30** | **30** |

## 2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан (мянган төгрөгөөр)

| Код | Үзүүлэлт | Өмнөх он | Тайлант он |
|---|---|---|---|
| **II** | **НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН** | **151459.9** | **290,258.41** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **151459.9** | **290,258.41** |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | **151459.9** | **220,912.34** |

| | | | |
|---|---|---|---|
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | **7228.72** | |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | | **220,912.34** |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 144231.18 | 200,818.61 |
| 213505 | Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, нэмэлт санхүүжилт төвлөрүүлэх шилжүүлэг | | 20,093.73 |
| **22** | **ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ** | | |
| **2200** | **Дотоод эх үүсвэрээр** | | **69,346.07** |
| **I** | **ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР** | **151459.89** | **290,258.41** |
| **1311** | **Нэмэлт санхүүжилтийн орлого** | **151459.89** | **290,258.41** |
| 131101 | Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж | 1000 | |
| 131103 | ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 144900.74 | 283,029.70 |
| 131104 | Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 5,559.15 | |
| 131105 | Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого | | 7,228.71 |

## 3. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 54,921.2 мянган төгрөгийн алдаа[1] илэрснээс аудитын явцад 32,643.3 мянган төгрөгийн алдааг залруулан 2,278.0 мянган төгрөгийн зөвлөмж, 20,000.0 сая төгрөгийн 1 албан шаардлага өглөө. Үүнд:

- Сангийн журам зөрчин санхүүжилт авч бараа материал худалдан авч зарцуулсан, гэрээний дагуу олгосон зээлийн авлага дутуу бүртгэснийг аудитын явцад залруулсан.
- ОНХС-гийн хөрөнгөөр хийгдсэн хөрөнгийг бүртгэлд тусгаагүй байсныг аудитын явцад залруулсан.

Аудитаар нийт 22,278.0 мянган төгрөгийн зөрчил[2] илэрснээс, 2,278.0 мянган төгрөгийн 3 зөвлөмж өглөө.

### 3.1 Албан шаардлага

***3.1.1*** Иргэдийн саналаар дэмжигдээгүй "Сумын ИТХ-ын төлөөлөгчдийг чадавхжуулах хөтөлбөр " 20.0 сая төгрөгөөр санхүүжүүлсэн зөрчил илэрлээ.Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1 дэх “төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах”, 16 дугаар зүйлийн 16.5.5 дахь “батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах", Сангийн сайдын 2021 оны 86 дугаар тушаалаар батлагдсан "ОНХС-ийн үйл ажиллагааны журам"-ын 4.3 дахь "Сум, дүүргийн түвшинд дараах үндсэн нөхцөлүүдийг хангасан хөрөнгө оруулалт, хөтөлбөр, төсөл, арга

*[1] Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/,*
*[2] Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.*

хэмжээг хэрэгжүүлнэ.Үүнд:", 4.3.2 дахь "ОНХС-ийн хөрөнгөөр санхүүжүүлэх хөрөнгө оруулалт, хөтөлбөр, төсөл, арга хэмжээ нь тухайн орон нутгийн иргэдийн саналаар дэмжигдэж эрэмбэлэгдсэн байх", 4.7 дахь "Энэ зүйлийн 4.6-д зааснаар ОНХС-ийн хөрөнгийг зарцуулах зөвшөөрөхгүй зардалд дараах хамаарах ба үүгээр хязгаарлагдахгүй", 4.7.5 дахь "Орон нутгийн иргэдийн саналыг аваагүй орон нутгийн төсвийн төлөвлөгөөнд тусгаж батлаагүй зардал, арга хэмжээ" гэсэн заалтыг тус тус зөрчсөн байна.

*Шийдвэрлэсэн* нь: Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр хийгдэх төсөл, арга хэмжээний хүрэх үр дүнг хангаж ажиллах.

**3.2 Зөвлөмж**

***3.2.1 Зардалтай холбоотой асуудал***

*Илрүүлэлт:* Хоршоо хөгжүүлэх сангийн журам зөрчин өвс тэжээлийн нөөц бүрдүүлсэн, бараа материал худалдан авч орчны тохижилт хийсэн зөрчил илэрсэн нь Төсвийн тухай хуулийн 14-р зүйлийн 14.2.3-д "өөрийн эрхлэх асуудлын хүрээнд төсвийг үр ашигтай удирдах, гүйцэтгэлийг хангах", 16-р зүйлийн 16.5.6-д "дотоод аудитын үйл ажиллагааг хэрэгжүүлэх" Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 18-р зүйлийн 18.1-д "Нягтлан бодох бүртгэлийг удирдан зохион байгуулах үүргийг аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага хүлээнэ" Хоршоо хөгжүүлэх сангийн журмын 1.3- д Сан нь Төрийн сангаас гадуур данстай байхыг хориглох бөгөөд журмын 1.2 т заасан дансанд хоршоо, жижиг, дунд үйлдвэрийг хөгжүүлэхээс бусад төрлийн санхүүжилт байршуулахыг хориглоно.", гэсэн заалтуудтай нийцэхгүй байна.

***Өгсөн зөвлөмж**:* Сангийн хөрөнгийг журмын дагуу зарцуулах,

**3.2.2 Дотоод, хяналт хариуцлагатай холбоотой асуудал**

Илрүүлэлт: Мянгад сумын Төвлөрүүлэн захирагчийн нэгтгэгдсэн сумын ЗДТГ, ИТХ, ОНХС, СХС-ийн санхүүгийн үйл ажиллагаанд тавих дотоод хяналт сул байгаагаас 2023 оны санхүүгийн тайлангийн аудитаар 54,921.2 мянган төгрөгийн 5 алдаа, 6 зөрчил илэрсэн байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.10-т "өөрийн эрхлэх асуудлын хүрээнд дотоод аудитын үйл ажиллагааг хэрэгжүүлэх" гэж заасныг зөрчсөн "нийцсэн бөгөөд зохистой байх" батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Өгсөн зөвлөмж: Төсвийн тухай хуулийн 14.2.10 дахь заалтыг мөрдөж, өөрийн эрхлэх асуудлын хүрээнд төсөвт байгууллагуудад дотоод хяналтыг хэрэгжүүлж ажиллах

Дээрх зөвлөмжийн биелэлтийг Ховд аймаг дахь Төрийн аудитын газарт 2024 оны 6 дугээр сарын 25-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

## 4. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/мян төгрөгөөр/

| Алдааны товч утга | Нийт алдаа | Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан | Буруу тусган илэрхийл сэн | Үүнээс | Зөвлөмж |
|---|---|---|---|---|---|
| | | | | Залруулсан | |

| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| Сангийн журам зөрчин санхүүжилт авч бараа материал худалдан авч зарцуулсан, гэрээний дагуу олгосон зээлийн авлага дутуу бүртгэсэн | 1 | 1,000.00 | 1 | 1,000.00 | | | 1 | 1,000.00 | | |
| ОНХС-гийн санхүүжилтээр хийгдсэн хөрөнгийг бүртгэлд тусгаагүй | 1 | 13,000.00 | 1 | 13,000.00 | | | 1 | 13,000.00 | | |
| Дүн | 2 | 14,000.00 | 2 | 14,000.00 | | | 2 | 14,000.00 | | |

**Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл**

| Зөрчлийн товч утга | Нийт зөрчил | | Үүнээс | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | Төлбөрийн акт | | Албан шаардлага | | Зөвлөмж | |
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн |
| Мянгад сумын Засаг даргын нэгтгэгдсэн сумын ЗДТГ, ИТХ, ХХС, ОНХС-ийн санхүүгийн үйл ажиллагаанд тавих дотоод хяналт сул байгаагаас 2023 оны санхүүгийн тайлангийн аудитаар 54,921.2 мянган төгрөгийн 5 алдаа 6 зөрчил илэрсэн байна | 1 | | | | | | 1 | |
| Иргэдийн саналаар дэмжигдээгүй "Сумын ИТХ-ын төлөөлөгчдийг чадавхжуулах хөтөлбөр " 20.0 сая төгрөгөөр санхүүжүүлсэн. | 1 | 20,000.0 | | | | | 1 | 20,000.0 |
| Дүн | 2 | 20,000.0 | | | | | 2 | 20,000.0 |